



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2025, 02.05 № 02/177
танай _____-ны № _____-т

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын
даатгалын газрын дарга Л.ОЧИРБАЛ
ТАНАА

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хүргүүлж байна.

Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт . . . хуудастай.



Ч.БОЛД



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/405/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Аккаунт траст аудит ХХК-ийн
захирал: П.Наранцэцэг
Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НТАГ	Нийслэл дэхь төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СНАХ	Санхүү нийцлийн аудитын хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 09/177
танай _____-ны № _____-т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Л.ОЧИРБАЛ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд НДС-аас зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 2,539,578.9 мянган төгрөг олгож, гүйцэтгэлээр 2,418,998.8 мянган төгрөг буюу 95.3 хувийг зарцуулж, үлдэгдэл 120,581.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 89.0 хувийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

09.03.2025

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,565,113.50	33,759,940.50
35	БАРАА МАТЕРИАЛ	19,565,113.50	33,759,940.50
35400	Хангамжийн материал	19,565,113.50	33,759,940.50
35410	Бичиг хэргийн материал	1,632,340.00	1,613,250.00
35420	Аж ахуйн материал	13,433,900.00	16,783,800.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,807,800.00	14,209,800.00
35470	Бусад хангамжийн материал	691,073.50	1,153,090.50
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,076,701,615.44	1,991,034,580.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,076,701,615.44	1,991,034,580.83
39200	Биет хөрөнгө	2,040,829,171.71	1,955,495,212.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,183,034,461.99	2,183,034,461.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(281,984,819.64)	(331,479,345.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,210,000.00	12,210,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,884,000.00)	(7,326,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	161,168,907.20	174,107,644.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,750,027.94)	(100,026,796.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	140,316,311.90	153,204,019.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(107,281,661.80)	(128,228,772.33)
39300	Биет бус хөрөнгө	35,872,443.73	35,539,368.73
39301	Програм хангамж	1,332,300.00	1,332,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(915,956.27)	(1,249,031.27)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,456,100.00	35,456,100.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,096,266,728.94	2,024,794,521.33
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	532,008.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	532,008.90
41300	Өглөг	-	532,008.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	532,008.90
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,096,266,728.94	2,024,262,512.43
51	Засгийн газрын хувь оролцоо	2,096,266,728.94	2,024,262,512.43
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	776,548,011.93	776,548,011.93
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	776,548,011.93	776,548,011.93
51200	Хуримтлагдсан үр дүн	981,176,978.09	909,172,761.58
51210	Өмнөх үеийн үр дүн	981,176,978.09	981,176,978.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	(72,004,216.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	338,541,738.92	338,541,738.92
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,096,266,728.94	2,024,794,521.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,938,337,007.20	2,550,958,799.67
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,661,307.20	11,379,899.67
3	Нийтлэг татварын бус орлого	18,661,307.20	11,379,899.67
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,661,307.20	11,379,899.67
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,661,307.20	7,898,499.67
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	3,481,400.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,919,675,700.00	2,539,578,900.00
8	Төсвийн захирагчдаас	6,357,000.00	2,539,578,900.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,539,578,900.00
10	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,357,000.00	-
11	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,913,318,700.00	-
12	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,913,318,700.00	-
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,020,883,531.54	2,622,963,016.18
14	УРСГАЛ ЗАРДАЛ	2,020,883,531.54	2,622,963,016.18
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,891,658,747.83	2,429,900,871.73
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,467,832,117.99	1,980,460,920.24
17	Үндсэн цалин	856,862,174.99	1,069,359,751.83
18	Нэмэгдэл	254,575,027.00	360,237,290.90
19	Унаа хоолны хөнгөлөлт	169,007,282.00	302,456,123.53
20	Урамшуулал	187,387,634.00	248,407,753.98
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,861,547.00	248,611,254.62
22	Тэтгэврийн даатгал	126,890,398.51	175,089,259.94
23	Тэтгэмжийн даатгал	14,928,909.27	18,454,487.35
24	ҮОМШӨ-ний даатгал	12,021,716.98	9,282,119.34
25	Ажилгүйдлийн даатгал	2,758,786.90	8,830,944.99
26	Эрүүл мэндийн даатгал	29,261,735.34	36,954,443.00
27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,520,925.80	32,827,464.59
28	Гэрэл, цахилгаан	11,622,313.62	14,082,156.11
29	Түлш, халаалт	13,251,913.18	12,032,706.27
30	Цэвэр, бохир ус	6,646,699.00	6,712,602.21
31	Хангамж, бараа материалын зардал	52,187,836.50	24,162,031.00
32	Бичиг хэрэг	19,060,292.00	12,956,510.00
33	Тээвэр, шатахуун	1,420,700.00	-
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,178,394.50	4,399,826.00
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	1,200,000.00
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,808,450.00	5,605,695.00
37	Эд хогшил, урсгал засварын зардал	31,632,550.00	25,275,800.00
38	Багаж, техник, хэрэгсэл	8,922,010.00	806,800.00
39	Урсгал засвар	22,710,540.00	24,469,000.00

**Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,504,680.00	15,744,867.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,114,500.00	4,369,400.00
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,200,000.00	8,000,000.00
43	Даатгалын үйлчилгээ	-	22,000.00
44	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	81,784.00
45	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	-
46	Газрын төлбөр	56,500.00	171,700.00
47	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	906,000.00	1,179,600.00
48	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,068,696.00	1,920,383.00
49	Бараа үйлчилгээний бусад зардал	100,119,090.54	102,818,534.28
50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	253,000.00
51	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,569,090.54	102,565,534.28
52	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,224,783.71	193,062,144.45
53	Бусад урсгал шилжүүлэг	26,133,594.00	72,482,100.00
54	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,676,430.00	10,776,300.00
55	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,457,164.00	61,705,800.00
56	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	120,580,044.45
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,580,044.45
58	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	103,091,189.71	-
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,091,189.71	-
60	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(82,546,524.34)	(72,004,216.51)
61	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(82,546,524.34)	(72,004,216.51)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д-д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,913,318,700.00	2,539,578,900.00
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,913,318,700.00	2,539,578,900.00
6	Төсвийн захирагчдаас	-	2,539,578,900.00
7	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,539,578,900.00
8	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,913,318,700.00	-
9	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,913,318,700.00	-
10	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,913,318,700.00	2,530,578,900.00
11	УРСГАЛ ЗАРДАЛ	1,913,318,700.00	2,530,578,900.00
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,784,093,916.29	2,337,516,755.55
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,467,832,117.99	1,980,023,320.24
14	Үндсэн цалин	856,862,174.99	1,068,922,151.83
15	Нэмэгдэл	254,575,027.00	360,237,290.90
16	Унаа хоолны хөнгөлөлт	169,007,282.00	302,456,123.53
17	Урамшуулал	187,387,634.00	248,407,753.98
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,861,547.00	248,516,845.72
19	Тэтгэврийн даатгал	126,890,398.51	174,994,851.04
20	Тэтгэмжийн даатгал	14,928,909.27	18,454,487.35
21	ҮОМШӨ-ний даатгал	12,021,716.98	9,282,119.34
22	Ажилгүйдлийн даатгал	2,758,786.90	8,830,944.99
23	Эрүүл мэндийн даатгал	29,261,735.34	36,954,443.00
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,520,925.80	32,827,464.59
25	Гэрэл, цахилгаан	11,622,313.62	14,082,156.11
26	Түлш, халаалт	13,251,913.18	12,032,706.27
27	Цэвэр, бохир ус	6,646,699.00	6,712,602.21
28	Хангамж, бараа материалын зардал	46,410,791.50	26,393,841.00
29	Бичиг хэрэг	11,203,297.00	12,937,420.00
30	Тээвэр, шатахуун	1,420,700.00	-
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,178,394.50	4,399,826.00
32	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	1,200,000.00
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,888,400.00	7,856,595.00
34	Эд хогшил, урсгал засварын зардал	31,632,550.00	35,677,800.00
35	Багаж, техник, хэрэгсэл	8,922,010.00	11,208,800.00
36	Урсгал засвар	22,710,540.00	24,469,000.00
37	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,285,984.00	13,824,484.00
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,964,500.00	4,369,400.00
39	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,200,000.00	8,000,000.00
40	Даатгалын үйлчилгээ	-	22,000.00
41	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	81,784.00
42	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,000.00	-
43	Газрын төлбөр	56,500.00	171,700.00

**Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

44	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	906,000.00	1,179,600.00
45	Бараа үйлчилгээний бусад зардал	550,000.00	253,000.00
46	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	253,000.00
48	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,224,783.71	193,062,144.45
49	Бусад урсгал шилжүүлэг	26,133,594.00	72,482,100.00
50	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,676,430.00	10,776,300.00
51	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,457,164.00	61,705,800.00
52	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	120,580,044.45
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	120,580,044.45
54	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	103,091,189.71	-
55	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,091,189.71	-
56	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	9,000,000.00
57	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	-	9,000,000.00
58	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	9,000,000.00
59	Дотоод эх үүсвэрээр	-	9,000,000.00
60	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,000,000.00
61	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(9,000,000.00)
62	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	1,063,723,502.43	2,178,813,253.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	1,063,723,502.43	2,178,813,253.28
C04	Тайлант үеийн үр дүн	-	-	-82,546,524.34	-82,546,524.34
C05	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	981,176,978.09	2,096,266,728.94
C06	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
C07	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	981,176,978.09	2,096,266,728.94
C08	Тайлант үеийн үр дүн	-	-	-72,004,216.51	-72,004,216.51
C09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	776,548,011.93	338,541,738.92	909,172,761.58	2,024,262,512.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,539,578,900.00	2,418,998,855.55	120,580,044.45	95.3
2	УРСГАЛ ЗАРДАЛ	2,539,578,900.00	2,418,998,855.55	120,580,044.45	95.3
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,463,316,300.00	2,346,516,755.55	116,799,544.45	95.3
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,027,265,300.00	1,980,023,320.24	47,241,979.76	97.7
5	Үндсэн цалин	1,082,782,900.00	1,068,922,151.83	13,860,748.17	98.7
6	Нэмэгдэл	349,700,600.00	360,237,290.90	(10,536,690.90)	103.0
7	Унаа хоолны хөнгөлөлт	317,889,000.00	302,456,123.53	15,432,876.47	95.1
8	Урамшуулал	276,892,800.00	248,407,753.98	28,485,046.02	89.7
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	271,308,200.00	248,516,845.72	22,791,354.28	91.6
10	Тэтгэврийн даатгал	191,044,700.00	174,994,851.04	16,049,848.96	91.6
11	Тэтгэмжийн даатгал	20,065,800.00	18,454,487.35	1,611,312.65	92.0
12	ҮОМШӨ-ний даатгал	10,033,000.00	9,282,119.34	750,880.66	92.5
13	Ажилгүйдлийн даатгал	10,033,000.00	8,830,944.99	1,202,055.01	88.0
14	Эрүүл мэндийн даатгал	40,131,700.00	36,954,443.00	3,177,257.00	92.1
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,434,600.00	32,827,464.59	24,607,135.41	57.2
16	Гэрэл, цахилгаан	18,380,200.00	14,082,156.11	4,298,043.89	76.6
17	Түлш, халаалт	24,701,300.00	12,032,706.27	12,668,593.73	48.7
18	Цэвэр, бохир ус	14,353,100.00	6,712,602.21	7,640,497.79	46.8
19	Хангамж, бараа материалын зардал	28,612,300.00	26,393,841.00	2,218,459.00	92.2
20	Бичиг хэрэг	13,000,000.00	12,937,420.00	62,580.00	99.5
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,452,100.00	4,399,826.00	2,052,274.00	68.2
22	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	1,200,000.00	35,000.00	97.2
23	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,925,200.00	7,856,595.00	68,605.00	99.1
24	Эд хогшил, урсгал засварын зардал	56,287,600.00	44,677,800.00	11,609,800.00	79.4
25	Багаж, техник, хэрэгсэл	20,387,600.00	20,208,800.00	178,800.00	99.1
26	Урсгал засвар	35,900,000.00	24,469,000.00	11,431,000.00	68.2
27	Томилолт, зочны зардал	2,640,000.00	-	2,640,000.00	-
28	Дотоод албан томилолт	2,640,000.00	-	2,640,000.00	-
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,872,500.00	13,824,484.00	4,048,016.00	77.4

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,510,800.00	4,369,400.00	3,141,400.00	58.2
31	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
32	Даатгалын үйлчилгээ	882,900.00	22,000.00	860,900.00	2.5
33	Тээврийн хэрэгслийн татвар	127,500.00	81,784.00	45,716.00	64.1
34	Газрын төлбөр	171,700.00	171,700.00	-	100.0
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,179,600.00	1,179,600.00	-	100.0
36	Бараа үйлчилгээний бусад зардал	1,895,800.00	253,000.00	1,642,800.00	13.3
37	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,895,800.00	253,000.00	1,642,800.00	13.3
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,262,600.00	72,482,100.00	3,780,500.00	95.0
39	Бусад урсгал шилжүүлэг	76,262,600.00	72,482,100.00	3,780,500.00	95.0
40	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,150,800.00	10,776,300.00	3,374,500.00	76.2
41	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	62,111,800.00	61,705,800.00	406,000.00	99.3
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,539,578,900.00	2,418,998,855.55	120,580,044.45	95.3
43	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,539,578,900.00	2,418,998,855.55	120,580,044.45	95.3
44	Улсын төсвөөс санхүүжих	2,539,578,900.00	2,418,998,855.55	120,580,044.45	95.3
45	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131	127	4	96.9
46	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
47	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
48	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	-	100.0
49	Удирдах ажилтан	7	7	-	100.0
50	Гүйцэтгэх ажилтан	53	54	(1)	101.9
51	Үйлчлэх ажилтан	5	4	1	80.0
52	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	61	4	93.8
53	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	55	56	(1)	101.8
54	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	5	5	50.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газар нь ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлдэг, НДЕГ-ын харьяа байгууллага юм.

Тус нийгмийн даатгалын газрын зорилт нь дүүргийнхээ шимтгэл төлөгч ажил олгогч байгууллага, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн, шуурхай хүргэх, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, ач холбогдлыг ойлгуулан таниулах замаар хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулахад оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.Тухайлбал:

- Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоох тухай” 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” А/211 дугаар тушаалаар “Төсвийн орлого, зарлаын эдийн засгийн ангилал, Санхүү байдлын тайлангийн дансны жагсаалт, тэдгээрийн тайлбар”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан “Маягтын загвар, аргачлал батлах тухай” 2024 оны а/44/а/40 дугаар тушаал.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Тус газрын 2024 оны үйл ажиллагаанд НДЕГ-ын дотоод аудит, мониторингийн газраас хяналт шалгалт хийсэн бөгөөд тайлан нь гараагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар НДЕГ-ын даргын 2022 оны А/64 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,472.2 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Бараа материал	19,565.1	33,759.9	14,194.8
Үндсэн хөрөнгө	2,076,701.6	1,991,034.6	(85,667.0)
Нийт хөрөнгө	2,096,266.7	2,024,794.5	(71,472.2)
Өр төлбөр	-	532.0	532.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,096,266.7	2,024,262.5	(72,004.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,096,266.7	2,024,794.5	(71,472.2)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Бараа материал дансны үлдэгдэл 33,759.9 мянган төгрөг болж 14,194.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 32,002.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, НДЕГ-аас 2,382.4 мянган төгрөгийн маягт, 1,099.0 мянган төгрөгийн аж ахуйн материал шилжүүлэн авч, 21,289.4 мянган төгрөгийн материал зарцуулсантай тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,991,034.6 мянган төгрөгт хүрч 85,667.0 мянган төгрөгөөр буурсан нь 9,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, НДЕГ-ын 2024 оны А/140, А/166, А/1457 тоот тушаалууд, 01/1230 тоот албан бичиг болон ТӨБЗГ-ын 2024 оны 394 тогтоолоор нийт 16,826.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг шилжүүлэн авсан, тайлант онд байгуулсан болон шилжилж ирсэн хөрөнгийн элэгдэл нийт 111,493.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 532.0 мянган төгрөг болж өссөн нь ХХОАТ-ын 437.6 мянган төгрөг, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн өглөгийг төлөөгүйтэй холбоотой байна.

Эздийн өмчийн дүн 2,024,262.5 мянган төгрөг болж 72,004.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 72,004.2 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын нийгмийн даатгалын сангаас 2,379,554.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 73,881.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 32,788.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 4,462.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 113,105.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,104.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 134,149.9 мянган төгрөгөөр тус тус бууруулж, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолтой уялдуулан цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 461,893.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 59,983.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 2,640.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, 2,539,578.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,539,578.9 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 2,539,578.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,418,998.8 мянган төгрөг буюу 95.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 85,694.6 мянган төгрөгөөр, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын төсвийг 13,204.8 мянган төгрөгөөр, өмгөөлөл, хуулийн зөвлөхийн зардлын төсвийг 15.4 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлын төсвийг 126.0 мянган төгрөгөөр, зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардлын төсвийг 17,758.7 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлын төсвийг 406.0 мянган төгрөгөөр, хуульд заасан үндэслэлээр ажилтанд олгох тэтгэмж, урамшуулалын зардлын төсвийг 1,426.8 мянган төгрөгөөр, бусад тусламж дэмжлэгийн зардлыг 1,947.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, зориулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901 Нийгмийн даатгал	2,539,578.9	2,418,998.9	120,580.0	95.3
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,313,428.1	2,227,733.5	85,694.6	96.3
1.2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	35,580.0	22,375.2	13,204.8	62.9
1.3	80213-Өмгөөлөл, хуулийн зөвлөх	784.8	769.4	15.4	98.0
1.4	80219-Харуул хамгаалалтын зардал	3,726.0	3,600.0	126.0	96.6
1.5	80224-Зөвлөл, хороо, комиссын гишүүд	109,797.4	92,038.7	17,758.7	83.8
1.6	80802-Ажил олгоогоос олгох тэтгэмж	62,111.8	61,705.8	406.0	99.3
1.7	80813-Хуульд заасан үндэслэлээр ажилтанд олгох тэтгэмж, урамшуулал	2,746.8	1,320.0	1,426.8	48.1
1.8	80820-Бусад тусламж дэмжлэг	11,404.0	9,456.3	1,947.7	82.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

НДЕГ-ын харьяа байгууллагуудад шаардлагатай хөрөнгийг нэгдсэн худалдан авалт хийж хуваарилдаг тул тус газарт худалдан авалтын төсөв баталдаггүй байна. Тайлант онд НДЕГ-аас 2,382.4 мянган төгрөгийн маягт, 1,099.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, НДЕГ-ын даргын 2024 оны А/140, А/166, А/1457 тоот тушаалууд, 01/1230 тоот албан бичиг, ТӨБЗГ-ын 2024оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 394 тогтоолоор нийт 16,826.4 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг тус тус шилжүүлэн авсан байна. Мөн 9,000.0 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, шилэн дансны хуулийг мөрдөн ажиллах, өр авлага үүсгэхгүй байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аккаунт траст аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа, захирал П.Наранцэцэг нар, дараагийн шатны хяналтыг НТАГ-ын СНАХ-ийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2025 оны 01дүгээр сарын 22-ны өдрийн 46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 2,020,883.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,208.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалт, хэмнэлтийн горимыг баримтлан ажиллаж батлагдсан үйл ажиллагааны зардлыг 120,580.0 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 203,614.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг ил тод байршуулж мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн 1,587,411.9 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 3 залруулга, 1 зөвлөмж хүргүүлэх саналыг асуудлын бүртгэлээр танилцуулсан.

Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, залруулах боломжгүй 1 зөрчлийг аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны хуулийг мөрдөөгүй 483,665.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	483,665.4	-	-	-
Нийт дүн	1	483,665.4	-	-	-

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөвлөмжийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 461,380.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлийн орлого, зарлага 442,634.7 мянган төгрөгөөр илүү, төвлөрүүлэг 14,370.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан байна.
- Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын дүнгээс нийгмийн даатгалын тайлангийн дүн 3,843.9 мянган төгрөгөөр /дутуу/ зөрүүтэй тайлагнагдсан байна. Эдгээр алдаа нь УСНББОУС1-3.2 “Улсын секторын байгууллагуудын Нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд тусгах мэдээллийн чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн шинжүүд юм” гэж заасантай нийцээгүй, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар 532.0 мянган төгрөгийн санхүүгийн зөрчил² илэрсэнд 532.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Өр төлбөр үүсгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 8 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/													
Д · Д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	532.0	1	532.0	-	-	1	532.0	-	-	-	-
2	Мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдлийн орлого, зарлага 442,634.7 мянган төгрөгөөр илүү, төвлөрүүлэг 14,370.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан байна.	1	457,004.9	-	-	1	457,004.9	1	457,004.9	-	-	-	-
3	НДШ-ийн зардлын дүнгээс НД-ын тайлангийн дүн 3,843.9 мянган төгрөгөөр /дутуу/ зөрүүтэй тайлагнагдсан байна.	1	3,843.9	-	-	1	3,843.9	1	3,843.9	-	-	-	-
	Дүн	3	461,380.8	1	532.0	2	460,848.8	3	461,380.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд ХХОАТ-ын 437.6 мянган төгрөгийн, НДШ-ийн 94.4 мянган төгрөгийн, нийт 532.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	532.0	-	-	-	-	1	532.0	-	-	-	-
Дүн	1	532.0	-	-	-	-	1	532.0	-	-	-	-

Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 203,614.0 төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	203,614.0	-	-	1	203,614.0		
Дүн	1	203,614.0	-	-	1	203,614.0		



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 51/10310474
НТХС-2025/405/НМ-СТА-Тулз

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 203,614,000.00 (хоёр зуун гурван сая зургаан зуун арван дөрвөн мянган) төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудит хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-д аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол, заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг ил тод байршуулж мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянгол дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга Л.Очирбал, санхүү бүртгэлийн тасгийн дарга С.Отгонцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН1:

АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

П.НАРАНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС

1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02043451

[illegible]

Утас: +976 70007734
Факс: +976 70007734

Цахим шуудан: ub@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Нийслэлийн өмчийн нэгдүгээр байр,
Ерөнхий сайд Амарын гудамж, Сүхбаатар
дүүрэг Улаанбаатар-15160, Монгол Улс